



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 1,264,500.00 төгрөг (нэг сая хоёр зуун жаран дөрвөн мянга таван зуу)-ийн балансын үнэ, 327,118.44 төгрөг (гурван зуун хорин долоон мянга нэг зуун арван найман төгрөг дөчин дөрвөн мөнгө)-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Эрдэнэс критикал минералс" төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлсүгэй.

2. "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Х.Ганчулуун, "Эрдэнэс критикал минералс" төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий инженер бөгөөд Үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга М.Болдбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системд бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2026 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000143

2026/6-1-huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
.....77..... дугаар тогтоолын хавсралт



**"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) |
|-----------------|-----------------------|------------------------|------------|-------------|---|---|---|
| 1 | Ёмкост 25 тн | 1981.01.01 | 1 | ш | 27,000.00 | 6,987.77 | 20,012.23 |
| 2 | 10 тн өргөх төхөөрөмж | 1985.12.31 | 1 | ш | 1,237,500.00 | 320,130.67 | 917,369.33 |
| Нийт дүн | | | | | 1,264,500.00 (нэг сая хоёр зуун жаран дөрвөн мянга таван зуу) | 327,118.44 (гурван зуун хорин долоон мянга нэг зуун арван найман төгрөг дөчин дөрвөн мөнгө) | 937,381.56 (есөн зуун гучин долоон мянга гурван зуун наян нэгэн төгрөг тавин зургаан мөнгө) |